



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 18 өдөр


Дугаар 41142

Улаанбаатар хот

Г Түр журам батлах тухай Г

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалаар баталсан “Коронавируст халдварт (Ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Биеийн тамир, спортын улсын хороонд (Ковид-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлж, дагаж мөрдөж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны нэгжийн дарга нар, нийт ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Г.Одбаатар/-т даалгасугай.



162101527

Биетийн тамир, спортын улсын хорооны  
даргын 2021 оны 05 сарын 18 өдрийн  
туслаалын хавсралт



**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНД “КОВИД-19” ЦАР  
ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ТҮР ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Коронавируст халдварт /Корона-19/-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журмын зорилго нь Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд халдварт хамгааллын дэглэм сахиулах, ажил үйлчилгээг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

1.2. Биетийн тамир, спортын улсын хороо /байгууллага/, түүний ажилтан, албан хаагчид нь энэхүү журмыг дагаж мөрдөн ажиллана.

Хоёр. Коронавируст халдварын үед байгууллагын зүгээс хийх зохион байгуулалтын арга хэмжээ

2.1. “COVID19 QR verify” аппликашныг татан авч нийтэд ил, хяналт тавьж болохуйц газар байршуулах, QR кодыг уншуулж нэвтрүүлэх;

2.2. Иргэдэд үйлчлэх цэгт эсвэл гадаа хаалганы дэргэд биетийн халуун хэмжигч болон гар халдваргүйжүүлэх уусмал байршуулах, ажилтан, албан хаагчдын биетийн дулааныг тогтмол хэмжиж байх;

2.3. Ажилтан, албан хаагчдын биетийн дулаан 38 хэмээс дээш байх, амьсгалын замын цочмог халдварын шинж тэмдэг (толгой өвдөх, ханиах, найдаах, хамраас нус тоожих) илэрсэн тохиолдолд гэрт нь буцаах, эрүүл мэндийн байгууллагад хандахыг зөвлөх;

2.4. Байгууллагын нэгдүгээр давхарт гарах хаалганд хамгийн ойр байрлах хэсэгт байгалийн агааржуулалттай “түр тусгаарлах өрөө”-г бэлтгэж, цэвэр ус, нэг удаагийн аяга, цаасан алчуур, ариун цэврийн цаас, хогийн уут, гар халдваргүйжүүлэгч байршуулах;

2.5. Түр тусгаарлах өрөөнд хэрэглэх эмнэлгийн анхны тусlamжийн иж бүрдэл, хамгаалах хувцас хэрэгсэл (амны хаалт, нэг удаагийн халаад, бээлий, улавч, нүдний шил, нүүрний хаалт, малгай) асуумж хуудас, халдваргүйжүүлэх уусмалтай шүршигч сав, гар халдваргүйжүүлэгчийг бэлтгэх;

2.6. Халдварын сэжигтэй тохиолдлыг түр тусгаарлах ажлыг зохион байгуулах ажилтныг томилж, ажиллах зааварчилгаа (мэдээлэл дамжуулах урсгал, авах арга хэмжээ) өгсөн байх;

2.7. Байгууллагад “Ковид-19”-ийн сэжигтэй тохиолдол илэрсэн тохиолдолд Улсын онцгой газрын даргын “Түр журмыг шинэчлэн батлах тухай” 2020 оны 41 дүгээр тушаалын 6 дахь хэсэг /Сэжигтэй тохиолдол илэрвэл авч хэрэгжүүлэх арга хэмжээ/-т заасны дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

2.8. Байгууллага дотор ариун цэвэр, халдварт хамгааллын дэглэмийг мөрдүүлж, халдвартгүйжүүлэлтийг журмын дагуу хийх, үйлчилгээний албан хаагчдыг ариутгал, цэвэрлэгээний материалыар тогтмол хангах;

2.9. Байгууллагын нийт ажилтан, албан хаагчдын эрүүл мэнд, дархлааг дэмжих, стрессгүй орчныг бүрдүүлэхэд онцгой анхаарах, гар халдвартгүйжүүлэх уусмал, амны маскаар хангах ажлыг шат дараатай хэрэгжүүлэх;

2.10. Халдвараас урьдчилан сэргийлэх амны хаалт зүүх, зайд барих, гараа угаах, халдвартгүйжүүлэх санамж, зөвлөмж, тэмдэг, тэмдэглэгээг үйлчилгээний танхим, албан тасалгаа, ариун цэврийн өрөөнд хүний нүдэнд ил харагдахуйц газарт байршуулах;

2.11. Засгийн газар, Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийг үндэслэн байгууллагын ажилтан, албан хаагчдын тодорхой хувийг гэрээс цахимаар ажиллах боломжийг бүрдүүлж, ажиллах хуваарийг гаргаж, ээлжээр эсвэл богиносгосон цагаар ажиллуулах зэргээр ажлын байрны нягтралыг бууруулах, ажлын байранд хүний бөөгнөрөл үүсгэхгүй байх талаар тодорхой шийдвэр гаргаж ажиллах;

2.12. Коронавируст цар тахлын халдварын үед халдварын сэжигтэй иргэнийг байгууллагад нэвтрүүлэхгүй байх, сэжигтэй тохиолдол илэрсэн үед халдвараас сэргийлэх зорилгоор тухайн иргэнийг түр тусгаарлах;

2.13. Байгууллагаас зохион байгуулах хурал, зөвлөгөөн, уулзалт зэргийг цахимжуулах, албан хаагчид байгууллага дээрээ гадны хүн урихгүй цахимаар харилцах, өрөө тасалгаанд халдварт хамгааллын дэглэмийг мөрдүүлэх талаар байнга анхааруулж байх;

Гурав. Ажилтан, албан хаагчдын эрх, үүрэг.

3.1. Халдварт хамгааллын дэглэм сахихыг тухайн байгууллага, эрх бүхий албан тушаалтнаас шаардах эрхтэй;

3.2. Халдварт хамгааллын дэглэмтэй холбоотой зөвлөмжийг мэргэжлийн байгууллагаас авах эрхтэй;

3.3. Халдварт хамгааллын дэглэм сахиулахтай холбоотой асуудлаар гомдол гаргах, мэдээлэл өгөх эрхтэй;

3.4. Засгийн газар, Улсын онцгой комисс, мэргэжлийн байгууллага, Биеийн тамир, спортын улсын хорооноос гаргасан шийдвэр, заавар, зөвлөмж, үүрэг даалгаварыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх;

3.5. Гадны байгууллагын ажилтан, иргэнийг албан байгууллага дээрээ урихгүй байх, зайлшгүй тохиолдолд нэгдүгээр давхарт очиж хүн хоорондын зай барьж уулзах, албан ажил гүйцэтгэхдээ аль болох цахимаар, утсаар холбогдож ажиллах;

3.6. Халдвэр хамгааллын дэглэмийг сахиж мөрдөх; /амны хаалт зүүх, хүн хоорондын зай барих, ариун цэвэр, халдвартгүйжүүлэлт тогтмол хийх, гарцаа тогтмол угаах, агаар сэлгэх гэх мэт./

3.7. Ажилтан, албан хаагчид биенийн дулаанаа байнга хэмжих, амьсгалын замын цочмог халдвартын шинж тэмдэг илэрвэл нэгжийн даргад мэдэгдэн чөлөө авч гэртээ өөрийгөө тусгаарлах, эрүүл мэндийн байгууллагад хандах;

3.8. Хувийн ариун цэврийг сайтар сахих, эд зүйлсээ солилцохгүй байх, хүн хоорондын зай барьж мэндчилэх, байгууллагын өрөө тасалгаагаар хэсэхгүй байх, хүний бөөгнөрөл үүсгэхгүй байх, байгууллагын ариун цэврийн өрөөг зүй зохистой ашиглах;

3.9. Өөрийн ажлын ширээ сандал, компьютер, шүүгээ зэрэг албан тасалгаан дахь эд зүйлийн гар хүрэх гадаргууг 2 цаг тутамд цэвэрлэн халдвартгүйжүүлэх;

3.10. Ажлын цаг, ажиллах горимд өөрчлөлт орсон тохиолдолд байгууллагын удирдлагаас гаргасан шийдвэрийг дагаж мөрдөх, цахимаар гэрээсээ ажиллаж байгаа тохиолдолд гадуур сэлгүүцэхгүй, айл хэсэхгүй, зочин урихгүй байж, мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийн дагуу халдвэр хамгааллын дэглэм баримтлах;

3.11. Улсын онцгой комиссын даргын 2021 оны 42 дугаар тушаалаар батлагдсан “Хот болон орон нутаг хооронд зорчих иргэдийн хөдөлгөөнийг зохицуулах түр журам”, 43 дугаар тушаалаар батлагдсан “Гэрийн ажиглалтын үйл ажиллагааг зохицуулах түр журам”, “Тусгаарлан эмчлэх үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ыг дагаж мөрдэж ажиллах;

3.12. Албан үүргээ хэрэгжүүлэх явцдаа энэхүү журмыг зөрчсөн төрийн албан хаагчид Төрийн албаны тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хариуцлага ногдуулна.